

Дундговь аймаг дахь
Төрийн аудитын газар



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

“ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО
ТОГТОЛЦООНЫ ҮР НӨЛӨӨ”-д ХИЙСЭН ГҮЙЦЭТГЭЛИЙН
АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

АУДИТЫН КОД: ГНАГ-2024/19-ШТА-ГА

Дундговь аймаг дахь Төрийн аудитын

газрын дарга, тэргүүлэх аудитор

Р.Мөнхтогтох Утас: 70592439

Аудитын менежер: Т.Оюун-Эрдэнэ

Утас: 70592225

Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

Ахлах аудитор Ч.Бэрхсайхан

Аудитор О.Баярсайхан

Шинжээч Г.Үүрийнтуяа

Утас: 7059-3208

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт
мэдээллийг дараах хаягаар авна уу.

Цахим хуудас: www.audit.mn

“ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО ТОГТОЛЦООНЫ ҮР НӨЛӨӨ”-Д
ХИЙСЭН ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

Огноо: 2024.11.25

Нэг. Ерөнхий мэдээлэл

Аудитын код:	ГНАГ-2024/19-ШТА-ГА	Шалгагдсан байгууллага, нэгжийн нэр:	Аймгийн ТАСЗ, АЗДТГ, Төрийн байгууллагууд
Аудитын нэр:	“Төрийн байгууллагын хүний нөөцийн бодлого, тогтолцооны үр нөлөө”		
Аудит хийсэн бүтцийн нэгжийн нэр:	Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар	Аудит хийсэн баг, албан тушаалтан:	Аудитын 2 дугаар нэгж

Хоёр. Аудитын үр дүн:

2.1 Аудитын зорилго, хамрах хүрээ:

Төрийн байгууллагын хүний нөөцийн бодлого, тогтолцооны үр нөлөөнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, дүнг Улсын Их Хурал болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэсэн.

Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Төрийн байгууллагын хүний нөөцийн бодлого, хууль эрх зүйг хэрэгжүүлэх тогтолцоо бүрдсэн эсэх;
- Төрийн байгууллагуудын хүний нөөцийн тогтолцоо нь сайн засаглалыг бий болгож байгаа эсэх.

Аудитад төрийн захиргааны, төрийн тусгай, улс төрийн, төрийн үйлчилгээний албан тушаалтнуудыг ажиллуулж байгаа төрийн байгууллагуудын үйл ажиллагааны стратеги, хүний нөөцийг хөгжүүлэх дэд хөтөлбөрийг Монгол Улсын дунд, урт хугацааны хөгжлийн бодлоготой уялдуулан боловсруулж, батлуулж, мөрдөж байгаа байдлыг аудитад хамруулсан.

2.2 Бүлэг А. Аудитын дүн:

1. Гол асуулт / аудитын дэд зорилт 1: Төрийн байгууллагын хүний нөөцийн бодлого, хууль эрхзүйг хэрэгжүүлэх тогтолцоо бүрэн бүрдсэн үү?

- Хариулт: Төрийн байгууллагын хүний нөөцийн бодлого төлөвлөлтийг сайжруулж, дутагдалтай байгаа боловсон хүчнийг бэлтгэхэд чиглүүлэх шаардлагатай байна.

1.1 Төрийн байгууллагуудын хүний нөөцийн баримталж буй бодлогын зорилт арга хэмжээ нь нэгдмэл бус, харилцан уялдаа холбоо муу байна.

Аймгийн хүний нөөцийн удирдлага, зохион байгуулалтай холбоотой нэгдсэн бодлого хөтөлбөр 2012-2020 онд байхгүй, аймгийн бодлогын баримт бичгүүдэд тусгайлсан зорилт тусгагдаагүй, зарим салбарын хүрээнд хэсэгчлэн төлөвлөсөн нэгдмэл бус, харилцан уялдаа холбоо муутай байна.

Аймгийн Засаг даргын бодлогын баримт бичигт тусгасан дийлэнх арга хэмжээг 100 хувийн гүйцэтгэлтэйгээр үнэлсэн байна. Бодит байдалд мэргэжлийн боловсон хүчин дутагдалтай байгаа, хэрэгжилтийг үнэлэх үзүүлэлтүүдийг бодитоор хэмжээгүй, хүрсэн түвшин нь тодорхойгүй, хэрэгжилт хангалтгүй байгаа нь үнэлгээ бодитой бус байгааг харуулж байна.

ЗГХЭГ-аас аймгийн ЗДТГ-ын үйл ажиллагаанд жил бүр хяналт шинжилгээ, үнэлгээ хийж тайлан гаргадаг бөгөөд тайланд хүний нөөцийн хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ тусгагдсан байдаг. Хүний нөөцтэй холбоотой 2019-2023 онд хэрэгжүүлсэн арга хэмжээний үнэлгээний дундаж 81.4 хувь гарсан ба хамгийн сүүлийн 2023 оны тайланд хамгийн бага буюу 70 хувьтай үнэлэгдсэн байгаа нь ЗДТГ-ын хүний нөөцийн хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ бодитой бус байгааг баталж байна.

1.2 Аймгийн хүний нөөцийн хангалт сүүлийн жилүүдэд нэмэгдэж байгаа боловч сумдын эрүүл мэнд, боловсрол, ХАА-н салбарт мэргэжлийн албан хаагчийн дутагдал өндөр байна.

Дундговь аймгийн хэмжээнд 2023 оны жилийн эцсийн байдлаар 3,093 төрийн албан хаагч ажиллаж байгаагаас ТҮ-ний албан хаагч 2,479 буюу 80.1 хувийг, ТЗ-ны албан хаагч 398 буюу 12.9 хувийг эзэлж байгаа бол УТ-ийн албан хаагч 115 буюу 3.7 хувийг эзэлж байна. Нийт төрийн албан хаагчдын 53.2 хувь нь аймгийн төв, Сайнцагаан суманд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн байгууллагад, 46.8 хувь нь бусад сумдын төрийн байгууллагад харьяалагдаж байна.



График 1. Хүний нөөцийн хангалт салбараар
Графикаас харахад хүний нөөцийн хангалт хөдөө аж ахуйн салбарт 71.0 хувь, эрүүл мэндийн салбарт 84.2 хувь буюу хамгийн бага, хууль, хяналтын салбарт 95.8 хувь байгаа нь хамгийн өндөр байна.

1.3 Оюутнуудад дэмжлэг олгохтой холбоотой шалгуур үзүүлэлт тодорхойгүй, дэмжлэг олгох талаар олон нийтэд ил тод, нээлттэй зарлаж, сонгон шалгаруулалт зохион байгуулсан баримт материал байхгүй байна. Энэ нь өрсөлдөөнийг хязгаарлах, тэгш бус байдлыг бий болгох үр дагавартай байна.

Аймгийн хүний нөөцийн дэд хөтөлбөрийг 2021 оноос орон нутагт хэрэгцээтэй боловсон хүчнийг шинээр бэлтгэх, боловсон хүчний хангалтыг нэмэгдүүлэх, ажиллах орчин нөхцөл, нийгмийн баталгааг хангах зэрэг зорилттойгоор хэрэгжүүлсэн байна. Хөтөлбөрийн хүрээнд 2021-2024 оны эхний хагас жил хүртэлх хугацаанд нийт 331 төрийн албан хаагч, оюутанд 966.2 сая

төгрөгийн дэмжлэг үзүүлсэн ба нийт олгосон дэмжлэгийн 55.2 буюу 523.4 сая төгрөгийг 2024 онд олгожээ. Тус хөтөлбөрөөс ажилчдын нийгмийн баталгааг хангах орон сууцны дэмжлэгт 648.0 сая төгрөг, эмчилгээний зардалд 84.0 сая төгрөг, сургалтын төлбөрт 158.2 сая төгрөг, мөнгөн дэмжлэгт 40.0 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

График 2. ТАХ-ийн дэмжлэг салбараар



Дэмжлэг олгосон хэмжээг тухайн салбарын хүний нөөцийн хангалтын хувьтай харьцуулсан шинжилгээ хийлээ.

Салбарын хувьд боловсон хүчин хамгийн их дутагдалтай хөдөө аж ахуйн салбарт 34.6 сая төгрөг буюу нийт төсвийн 3.5 хувийг хуваарилсан бол хүний нөөцийн хангалт харьцангуй дээгүүр үнэлэгдсэн соёл, урлаг, спорт, төрийн захиргааны салбарт илүү төсөв хуваарилсан байна. Харин

хүний нөөцийн дутагдал ихтэй эрүүл мэнд, боловсролын салбарт харьцангуй өндөр төсөв хуваарилсан байна.

Хөтөлбөрт хамрагдсан 331 төрийн албан хаагчдаас 309 албан хаагч нь ажлаа үргэлжлүүлэн гүйцэтгэж байгаа бол 22 албан хаагч нь ажлаасаа гарсан боловч гэрээнд заасны дагуу ямар нэгэн арга хэмжээ аваагүй байна. Орон сууцны дэмжлэг авсан 2 албан хаагчаас 1 нь Баянхонгор аймагт шилжин ажиллаж байгаа нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй байх тул орон нутагт ажиллуулах шаардлага хүргүүлэх, ажиллаагүй тохиолдолд олгосон дэмжлэгийг гэрээнд заасны дагуу буцаан төлүүлэх арга хэмжээг авах шаардлагатай.

Шинээр боловсон хүчин бэлтгэх дэмжлэгийн хувьд 2021-2024 онд нийт 91 оюутанд 188.9 сая төгрөгийн дэмжлэг олгосон байна.

Хүснэгт 1. Сургалтын төлбөрийн дэмжлэг авсан оюутны тоо салбараар /сая.төг/

Мэргэжлийн салбар	2021		2022		2023		2024		Нийт	
	тоо	Хэмжээ	тоо	Хэмжээ	тоо	Хэмжээ	тоо	Хэмжээ	тоо	Хэмжээ
Байгаль орчин					1	3			1	3.0
Гааль, татвар					1	3			1	3.0
Газар зохион байгуулалт			1	2.6					1	2.6
Хүнсний технологи					1	3			1	3.0
Инженер					1	2.3	1	3.3	2	5.6
Санхүү			1	1.8			1	2.1	2	3.9
Эрх зүй					1	1	1	3.0	2	4.0
Хөдөө аж ахуй	3	5.2	2	5.2	2	4.7	1	3.5	8	18.6
Соёл, урлаг					5	3.3	5	3.3	10	6.6
Боловсрол	3	7.8	6	13.5	1	1.5	7	22.5	17	45.1
Эрүүл мэнд	20	41.8	4	10.7	14	14.8	8	26.0	46	93.4
Дүн	26	54.7	14	33.8	27	36.6	24	63.7	91	188.9

Эх сурвалж: Аймгийн ЗДТГ-ын Төрийн захиргаа удирдлагын хэлтэс

Дэмжлэг авсан оюутнуудын 42 нь орон нутагтаа ирж ажиллаж байгаа, 5 нь ажиллаагүй, 44 нь төгсөөгүй, суралцаж байна. Ажиллаагүй 5 иргэнээс 1 нь сургалтын дэмжлэгийг буцаан төлсөн, 1 нь Улаанбаатар хотод хүүхдээ эмчлүүлж байгаа, 2 нь төрийн албаны ерөнхий шалгалтад тэнцээгүй гэсэн шалтгаанаар ажиллахгүй байгаа бол 1 нь шалтгаан тодорхойгүй байна.

Сургалтын төлбөрийн дэмжлэг авсан боловч орон нутагт ирж ажиллахгүй байгаа оюутнуудыг ирж ажиллаж байгаа эсэхэд хяналтыг тогтмол тавьдаггүй, ажиллуулах шаардлага хүргүүлдэггүй, ажиллаагүй тохиолдолд олгосон дэмжлэгийг гэрээнд заасны дагуу буцаан төлүүлэх ажлыг зохион байгуулаагүй байгаа нь хөтөлбөрийн үр дүнг бууруулж байна.

Иймд хүний нөөцийн хангалт, боловсон хүчний дутагдал, эрэлт хэрэгцээний судалгааг жил бүр хийж, судалгааны үр дүнд үндэслэн хүний нөөц хамгийн их дутагдалтай салбар, сумдад чиглүүлж, дэмжлэг олгох шалгуур үзүүлэлтийг тодорхой тусгаж, дэмжлэг олгох талаар нийтэд ил тод нээлттэй зарлаж, сонгон шалгаруулалтыг зохион байгуулж байх шаардлагатай байна.

ТАСЗ-д 2023 оноос 2024 оны эхний хагас жил хүртэлх хугацаанд давхардсан тоогоор 220 сул орон тоог нөхөх захиалга ирүүлж, 8 удаагийн шилжүүлэн томилох зарыг Дундговь аймгийн цахим хуудсанд байршуулсан байна.

ТАСЗ хүний нөөцийн дутагдалтай байдал, тогтвор суурьшилгүй ажилласан, хүний нөөцийн мэдээллийн удирдлагын нэгдсэн системийн боловсронгуй бус байдлаас шалтгаалан төрийн байгууллагуудын томилгоонд тогтмол хяналт тавьж ажиллаагүй байна.

2016-2022 оны хооронд гарсан алдаатай шийдвэрээс үүдэлтэй төрд учирсан хохирлын мэдээллийг харууллаа.

Хүснэгт 2. Төрд учирсан хохирол /сая.төг/

	2016	2017	2018	2019	2020	2021	2022
Хохирлын тоо	16	21	4	5	9	8	6
Хохирлын хэмжээ	118.9	51.6	19.2	10.9	46.4	82.2	26.5
Барагдуулсан байдал	8.5	7.6	7.4	5.1	9.6	6.4	1.6
Барагдуулаагүй хохирол	110.4	35.1	11.9	5.7	36.8	75.7	24.8

Удирдлагын буруутай шийдвэрээс үүдэлтэй төрд учирсан хохирлыг салбараар нь авч үзвэл төрийн захиргааны байгууллагад хамгийн өндөр байсан бол боловсролын салбар удаалж байна. Харин эрүүл мэндийн салбарт хамгийн бага тохиолдол гардаг байна. Сүүлийн жилүүдэд удирдлагаас үүдэлтэй буруутай шийдвэрийн тоо эрс буурсан боловч төрд учирсан хохирлын хэмжээ өндөр, хариуцагч этгээдийн хохирол барагдуулсан байдал тун хангалтгүй хэмжээнд байна.

Иймд төрийн албан хаагчийн буруутай шийдвэрийн улмаас төрд учирсан хохирлыг буруутай этгээдээр төлүүлэх ажлыг ТАЗ-тэй хамтран зохион байгуулах шаардлагатай байна.

2.3 Бүлэг Б. Аудитын дүн:

2. Гол асуулт / аудитын дэд зорилт 2: Төрийн байгууллагуудын хүний нөөцийн тогтолцоо нь сайн засаглалыг бий болгож байна уу?

Хариулт: Төрийн байгууллагуудын хүний нөөцийг хөгжүүлэх хөтөлбөр хэрэгжүүлсэн, ил тод байдал, шударга байдлын үнэлгээ өссөн байна.

2.1 Төрийн албан хаагчийг сургах, мэргэшүүлэх ажил хийгдэж байгаа боловч хэрэгцээ шаардлагыг тодорхойлох, хэрэгжилт үр дүнг тооцох ажил хангалтгүй байна.

Хүний нөөцийн дэд хөтөлбөрийн хүрээнд сургалт, хөгжлийн чиглэлээр 234.9 сая төгрөгийн төсөв зарцуулсан байна. Нийт төсвийн 133.5 сая төгрөг буюу 56.8 хувийг “Гадаадын хамтын ажиллагааг өргөжүүлж орон нутагт сайн туршлагыг нэвтрүүлэх” арга хэмжээнд зарцуулжээ.

Хүснэгт 3. Сургалт зөвлөгөөний мэдээлэл /2021-2023 он/

№	Сургалтын чиглэл	Хамрагдсан ТАХ-ийн тоо	Зарцуулсан төсөв /сая төг/
2023			
1	ТАХ-ийг чадваржуулах сургалт зохион байгуулах	310	34.1
2	Чадварлаг, мэдлэг боловсролтой, ёс зүйтэй төрийн алба, төрийн албаны зөвлөгөөн зохион байгуулж, харилцан туршлага солилцох	200	25.0
3	Гадаадын хамтын ажиллагааг өргөжүүлж орон нутагт сайн туршлагыг нэвтрүүлэх	30	133.5
2022			
4	“Төрийн албаны бүтээмж” сургалт	340	-
5	“Хүний хөгжлийг дэмжих жил”-ийн хүрээнд Төрийн албан хаагчийн чадавхыг бэхжүүлэх сургалт	103	17.5
2021			
6	Албан хаагчдаа хөгжүүлэх мэргэшүүлэх "ТАХ-ийн тасралтгүй хөгжил" гадаад дахь сургалт, семинар, зөвлөгөөн	130	24.8
	Нийт	1,113	234.9

Хүний нөөцийг хөгжүүлэх дэд хөтөлбөрийн хүрээнд төрийн албан хаагчийн мэдлэг боловсролыг дэмжих, мэргэшүүлэх сургалтын төлбөрийн дэмжлэгийг 170 албан хаагчид 158.2 сая төгрөгийг олгосон байна.

Хүснэгт 4. Сургалтын төлбөрийн дэмжлэг авсан албан хаагчдын мэдээлэл /сая.төг/

Салбар	Мэргэшүүлэх багц сургалт		Бакалаврын сургалт		Магистрын сургалт		Докторын сургалт		Нийт	
	Тоо	Хэмжээ	Тоо	Хэмжээ	Тоо	Хэмжээ	Тоо	Хэмжээ	Тоо	Хэмжээ
Байгаль орчин			1	0.5					1	0.5
Боловсрол	1	1.6	43	28.6	24	12.0			68	42.2
Нийгмийн хамгаалал							1	3.0	1	3.0
ОНӨААТҮГ			3	7.5					3	7.5
Соёл, урлаг, спорт	1	1.6	3	6.0					4	7.6
Төрийн захиргаа	14	23.3	19	22.6	2	2.0			35	47.9
Хөдөө аж ахуй	2	3.3	1	2.5	2	2.0			5	7.8
Хууль, хяналт	4	4.9	8	10.6	1	0.5			13	16.0
Эрүүл мэнд	2	3.2	12	6.0	26	16.5			40	25.7
Дүн	24	37.9	90	84.3	55	33.0	1	3.0	170	158.2

Эх сурвалж: Аймгийн ЗДТГ-ын Төрийн захиргаа удирдлагын хэлтэс

2.2 Мэргэжлийн байгууллагын судалгаагаар сүүлийн жилүүдэд шударга байдал, ил тод байдлын үнэлгээ өссөн үзүүлэлттэй гарсан байна.

Авлигатай тэмцэх газрын захиалгаар төрийн бус байгууллагаас улсын хэмжээнд яам, агентлагууд болон аймаг нийслэлийн ЗДТГ-ын ШБҮ-г жил бүр гаргадаг.

Хүснэгт 5. Шударга байдлын үнэлгээ (ШБҮ) 2015-2022

	2015	2016	2018	2019	2021	2022
--	------	------	------	------	------	------

Улсын дундаж	73.8	69.7	68.7	74.1	72.9	73.9
ЗДТГ дундаж	72.9	69.0	66.1	73.2	71.4	71.1
Дундговь аймгийн ЗДТГ	66.3	66.6	55.5	69.8	72.8	75.7

Эх сурвалж: Авилгатай тэмцэх газар

Манай аймгийн хувьд авлигын шууд бус тохиолдол 2015 оны байдлаар их байсан боловч жил ирэх тусам энэхүү тохиолдол багасаж үнэлгээ нь өссөөр байгаа нь харагдаж байна. Хэдийгээр авлигын шууд болон шууд бус тохиолдлын үнэлгээ өсөж байгаа боловч авлигын индекс өндөр гарахгүй байгаа бөгөөд энэ нь уг судалгаанд оролцож буй иргэд, ААН, байгууллагын төлөөллийн дийлэнх нь авлигын талаарх төсөөлөл бага байгаатай холбоотой.

Хүснэгт 7. Ил тод байдлын үнэлгээ 2015-2022

	2015	2016	2018	2019	2021	2022
Аймаг, нийслэлийн дундаж	60.1	53.6	48.9	72.4	54.3	54.0
Дундговь аймгийн ЗДТГ	61.3	57.5	32.8	61.6	60.3	57.5

Эх сурвалж: Авилгатай тэмцэх газар



Зөвлөмж

Аудитын нотлох баримт, аудитын дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан байгууллага, албан тушаалтанд зөвлөж байна.

Аймгийн Засаг даргад:

1. Төрийн байгууллагын хүний нөөцийн бодлоготой холбоотой зорилт, арга хэмжээг төрийн албан хаагчдын шинж байдал, суурь судалгаанд үндэслэн шалгуур үзүүлэлт, жил бүрийн хүрэх түвшин, санхүүжилтийн эх үүсвэрийн хамт бодитой тогтоож, аймгийн бодлогын баримт бичигт тусган хэрэгжүүлж, хэрэгжилт үр дүнг тооцон ажиллах;
2. Хүний нөөцийн хангалт багатай, мэргэжлийн боловсон хүчний дутагдалтай байгаа салбар, сумдыг ихээс бага руу тоон болон чанарын үзүүлэлтээр эрэмбэлж, хүний нөөцийн хангалтыг нэмэгдүүлэх, шинээр боловсон хүчин бэлтгэх, ТАХ-дыг тогтвор суурьшилтай ажиллуулах орчин нөхцөлийг бүрдүүлэхтэй холбоотой ажлыг шат дараалан хэрэгжүүлэх;
3. Дундговь аймгийн “Хүний нөөцийг хөгжүүлэх” дэд хөтөлбөрөөс дэмжлэг олгох шалгуур үзүүлэлтийг тодорхой тусгаж, дэмжлэг олгох талаар нийтэд ил тод нээлттэй зарлаж, сонгон шалгаруулалтыг зохион байгуулж байх;
4. Дундговь аймгийн “Хүний нөөцийг хөгжүүлэх” дэд хөтөлбөрөөс дэмжлэг, сургалтын төлбөр авсан боловч орон нутагт ажиллахгүй байгаа 1 иргэн, 2 оюутныг ажиллуулах талаар шаардлага хүргүүлэх, ажиллаагүй тохиолдолд гэрээнд заасны дагуу дэмжлэг, сургалтын төлбөрийг буцаан төлүүлэх;
5. Төрийн албан хаагчийг буруутай шийдвэрийн улмаас төрд учирсан хохирлыг буруутай этгээдээр төлүүлэх ажлыг ТАЗ-тэй хамтран зохион байгуулах.

ТАЗ-ийн Дундговь аймаг дахь Салбар зөвлөлд:

1. Хүний нөөцийн мэдээллийн удирдлагын нэгдсэн системд төрийн албан хаагчийн томилсон, ажлаас чөлөөлсөн мэдээлэл, сул орон тоо, төрийн албан хаагчийн шинж байдлын мэдээллийг тухайлсан хугацаанд байгууллага, салбар бүрээр нэгтгэж гарах боломжтой байдлаар системийн сайжруулалт хийж, хяналт хийх, тоон мэдээлэлд судалгаа, дүн шинжилгээ хийх боломжийг бүрдүүлэх саналыг ТАЗ-д хүргүүлж шийдвэрлүүлэх;
2. Төрийн байгууллагуудад шинээр бий болсон төрийн жинхэнэ албан хаагчийн сул орон тоо, томилгоонд хяналт тавьж, зөрчилтэй томилгоог тухай бүр залруулж байх.

Монгол Улс, Дундговь аймаг 48090, Сайнцагаан сүм, Нарлаг
баг, Нутгийн удирдлагын ордон Утас/Факс: 70-59-24-39
E-mail: dundgovi@audit.gov.mn 